



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар A/421

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 72 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын өмч хөрөнгөд 2021 оны жилийн эцсийн тооллого хийх комиссыг хавсралтаар байгуулсугай.

2. Тооллогын комисс (Б.Батбаяр)-т даалгах нь;

а. Тооллогыг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 12 дугаар сарын 13-ны өдрийн хооронд ажлын 14 хоногт багтаан явуулах;

б. Тус газрын балансад бүртгэлтэй барилга байгууламжийг тоолж, барилгын хувийн хэргийг шинэчлэх, мөн тооллогоор илэрсэн хөрөнгийн зөрчил арилгах;

в. Хөрөнгө материалыг нэг бүрчлэн нүдээр үзэн тоолж ажилтнуудын хөрөнгийн ашиглалтын картыг шинэчлэн, кодлон тооллогын бүртгэл үйлдэх;

3. Тооллогын нэгдсэн дүнг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор гаргаж байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, байгууллагын удирдлагад танилцуулахыг тооллогын комисс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001149

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2021 оны 11 сарын ...19...-ны  
өдрийн ...1/4... дугаар тушаалын хавсралт



Тооллогын комиссын бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Батбаяр	Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Н.Цэцэгдэлгэр	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
	Г.Нямбаяр	Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийн менежер
	Ц.Цэрэндулам	Хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн
Нарийн бичиг:	Т.Оюунтуул	Нягтлан бодогч